



146

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2009 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 175

Арвайхээр


Г Журам шинэчлэн батлах тухай

Аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.4; 3.1.5 дугаар заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Багийн жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аймгийн тэргүүний баг шалгаруулан шагнах журам”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Багийн ажлыг тогтмолжуулах, багаас иргэдэд үзүүлэх захиргааны үйлчилгээг чанар, хүртээмжтэй, хөнгөн шуурхай болгоход хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг дээшлүүлж ажиллахыг сумдын Засаг дарга наарт үүрэг болгосугай.

Гурав. Журмыг шинэчилсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 12 дугаар сарын 13-ний өдрийн 186 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.



ЗАСАГ ДАРГА - 2

Д.ТОГТОХСҮРЭН

09 06 12

147

Аймгийн Засаг даргын 200⁹ оны 06 дугаар
сарын 11 -ний өдрийн 17:5 дугаар
захирамжийн хавсралт

**БАГИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, АЙМГИЙН ТЭРГҮҮНИЙ БАГ ШАЛГАРУУЛАН
ШАГНАХ ЖУРАМ**

Нэг; Үндэслэл;

Монгол Улсын үндсэн хууль, "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам", 2008 оны 7 дугаар тогтоолоор батлагдсан "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн жишиг багийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт", аймгийн Засаг даргын 2008 оны 143 дугаар захирамжаар батлагдсан "Аймгийн жишиг сум, баг шалгаруулах журам", аймгийн Засаг даргын 2007 оны 252 дугаар захирамжаар батлагдсан "Баг бэхжүүлэх" аймгийн хөтөлбөр, 2007 оны "Журам батлах тухай" 307 дугаар захирамж, аймгийн ИТХ-ын 2008 оны 2/02 дугаар тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг нь энэхүү журмын эрх зүйн үндэслэл болно.

Хоёр; Зорилго;

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнг дээшлүүлж "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль", Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, бусад бсдлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн, багийн ажлыг тогтмолжуулах, багаас иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанар, хүртээмжтэй, ил тод, хөнгөн шуурхай, щударга болгох

Гурав; ХШҮ-ний зарчим;

3.1. Сумын ИТХ-ын тэргүүлэгчид, Засаг даргын хамтарсан шийдвэрээр байгуулагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсэг сумын бүх багуудын жилийн үйл ажиллагаанд ХШҮ хийж, үр дүнгийн үнэлгээний дагуу багуудыг цуваагаар байр эзлүүлсэн үнэлгээний жагсаалтаа дараа жилийн нэгдүгээр сарын 05-ны дотор аймгийн ЗДТГ-ын ТЗҮ-ын хэлтсийн ХШҮ-ний тасагт ирүүлнэ.

3.2. Аймгийн ЗДТГ-ын ТЗҮ-ын хэлтсийн ХШҮ-ний тасаг нь сумдаас ирсэн багуудын ХШҮ-ний үзүүлэлтийг үндэслэн нэгдүгээр сарын 10-ны дотор аймгийн бүх багуудыг цуваагаар байр эзлүүлж, 80.0-аас дээш хувийн үнэлгээ авсан эхний 10 багийн үйл ажиллагаанд газар дээр нь очиж ХШҮ хийж баталгаажуулна. Аймгийн нийт багууд ХШҮ-нээр 80.0 оноо авч чадаагүй тохиолдолд хамгийн өндөр хувь авсан 2 багт тусгай шагнал олгуулах саналыг ТЗҮ-ын хэлтсээс аймгийн Засаг даргын зөвлөлд оруулна.

3.3. ХШҮ-ний тасгийн ХШҮ хийсэн 10 багийн дүнг үндэслэн аймгийн ЗДТГ-ын ТЗҮ-ын хэлтсээс Засаг даргын зөвлөлд эхний 5 багийг аймгийн оны тэргүүний баг болгох саналаа оруулна.

3.4. Зөвлөлийн хурлаар хэлцэгдсэн багуудыг байр эзлүүлэн шалгаруулж аймгийн Засаг даргын шийдвэрээр шагнахаа.

Дөрөв; 1.. Аймгийн ЗДТГ-ын ТЗҮ-ын хэлтсийн ХШҮ-ний тасгаас аймгийн тэргүүний багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх үндсэн үзүүлэлт;

СҮМЫН БАГИЙН
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Д/ д	Үзүүлэлт	Гүйцэтгэлийн үнэлгээ		Ерөнхий үнэлгээ	
		Хувь	Оноо		
1.	Бодлогын зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн үнэлгээ	1. Монгол Улсын хууль, Засгийн газар, аймаг, сумын ИТХ-ын тогтоол, дээд шатны Засаг даргын баг, иргэдэд холбогдох заалт, шийдвэрийн сурталчилгээ, хэрэгжилт			
		2. Аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн багт холбогдолтой зорилтын хэрэгжилт			
		3. Багийн ИНХ-ын шийдвэрийн хэрэгжилт			
		4. Багийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, тайлагналт			
Үнэлгээний дундаж					
2.	Бодлогын зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ	1. Аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн багт холбогдолтой зорилтын биелэлт			
		2. Сумын Засаг даргаас багийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт			
		3. Монгол Улсын хуулиудаар олгогдсон багийн ИНХ, Засаг даргын бурэн эрхүүдийн хэрэгжилт			
		4. ЗГ-ын "Багийн хөгжлийг дэмжих" хөтөлбөр; "Баг бэхжүүлэх" аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аймгийн "жишиг баг" болох талаар зохион байгуулж буй ажил			
Үнэлгээний дундаж					
3.	Багийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ	1. Багийн ИНХ-ын тоо, чанар, үр дүн			
		2. Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт			
		3. Багтаа зохион байгуулсан бодит, бүтээлч ажлын үр дүн			
		4. Хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний үр дүн			
		5. Мал эмнэлгийн үйлчилгээний үр дүн			
		6. Байгаль хамгаалах ажлын үр дүн			
		7. Боловсролт, соёлын үйл ажиллагааны үр дүн			
		8. Байгаль, цаг агаарын гамшиг ослоос урьдчилан сэргийлэх ажлын үр дүн			
		9. Иргэний бүртгэл мэдээллийн, ажлын үр дүн			
		10. Нийгмийн хамгаалал, халамж үйлчилгээний талаар зохион байгуулсан ажлын үр дүн			
Үнэлгээний дундаж					
4.	Үйл ажиллагааны үр дагаврын үнэлгээ	1. Хүм амын ажил эрхлэлт, амжиргааны түвшиний байдал			
		2. Багийн төвийн тохижилт, ашиглалт			
		3. Хэрэглэгчдийн үнэлгээ			
Үнэлгээний дундаж					
Ерөнхий үнэлгээ					

ХШУ ХИЙСЭН

ЗӨВШӨӨРСӨН БАГИЙН ИНХ-ЫН ДАРГА
БАГИЙН ЗАСАГ ДАРГА

.....оны.....сарын.....өдөр

/

/

/

/

/

/

2. Сумын ИТХ, Засаг даргын хамтарсан шийдвэрээр байгуулагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсэг багийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэх нэмэлт үзүүлэлтийн жишиг загвар;

		1. ИНХ-ын тэргүүлэгчийн үйл ажиллагаа			
		2. ИНХ-ын даргын үйл ажиллагаа			
		3. Багийн ИНХ-ын албан хэргийн хөтлөлт, архивт бэлтгэн шилжүүлсэн байдал			
		4. ИНХ, тэргүүлэгчийн тогтоолын бүрдэл, хэрэгжилт			
5.	Багийн ИНХ-ын үйл ажиллагаа	5. Багийн ИНХ-ын тэргүүлэгчид, ИНХ-ын дарга, Засаг даргын үйл ажиллагааны тайлан мэдээллийг ИНХ-аар хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгсөн байдал			
6.	Багийн Засаг даргын албан хэрэг хөтлөлт, мэдээ, судалгаа	1. Багийн Засаг даргын шийдвэрийн бүрдэл, хэрэгжилт, архивт бэлтгэн шилжүүлсэн байдал 2. Өрхийн дэвтриний хөтлөлт 3. Багийн статистик үзүүлэлттэй холбоотой суурь судалгаа 4. Хүн ам, иргэний бүртгэлийн судалгаа 5. Мал, тээвэр амьтан, худаг, орон нутгийн өмчийн тооллого, бүртгэл 6. Мэдээ, судалгааны ирц, бодит байдал			

3. Сумын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсгийн иргэдээс авах "Хэрэглэгчдийн үнэлгээ"-ний загвар;

Д/д	Асуулт	Тийм /сайн/	Дунд зэрэг	Үгүй /муу/	Мэдэх гүй
1.	Танай багийн ИНХ-ын үйл ажиллагаа тогтмолжсон уу				
2.	Танай багийн ИНХ-ын дарга үүргээ ямар биелүүлж байна вэ				
3.	Та багийн Засаг даргынхаа үйл ажиллагаанд ямар үнэлгээ өгөх вэ				
4.	Танай багийн хүний эмчийн /баг, өрхийн эмнэлэг/-ийн үйлчилгээ ямар вэ				
5.	Танай багт мал эмнэлгийн үйлчилгээ чанартай сайн хийгддэг уу				
6.	Багийн ИНХ-ын дарга, Засаг дарга нар тантай уулзаж, таны санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэдэг уу				
7.	Багаас хууль, төгтоомж, төр, засгийн бодлого, шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажил ямар байна гэж Та дүгнэх вэ				
8.	Танай багт бүх нийтийн боловсрол, соёлын ажил хэр зохион байгуулагддаг вэ				
9.	Багаас зохион байгуулж байгаа нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээ ямар байна вэ				
10.	Та багийн ИНХ-даа оролцдог уу				
		ДҮН			x

4. Хэрэглэгчдийн үнэлгээг хөдөөд багийн насанд хүрсэн иргэдийн 3.0, аймаг, сумын төвд 1.0-хувиас доошгүй хувиас авсан байна.
 5. Хэрэглэгчдийн үнэлгээг дүгнэхдээ асуулгын хуудас бүрийн сайн, дунд зэрэг, муу гэсэн 3 үнэлгээ тус бүрийг доош дүгнэн, нийт хуудаснуудын дүнг сайн, дунд зэрэг, муугаар нь нэгтгэн сайн үнэлгээг 100-гаар, дундыг 50-иар үржүүлэн хооронд нь нэмж, нийлбэрийг нь 3 үнэлгээнийхээ нийлбэрт хувааж гаргана.

6. Багийн жилийн үйл ажиллагааны ХШҮ нь аймгийн Засаг даргын 2007 оны "Журам батлах тухай" 307 дугаар захирамжаар батлагдсан "Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журмын аргачлалаар хийгдэнэ.

Зургаа; Шагнал урамшуулал;

5.1. Оны аймгийн тэргүүний багуудыг байр эзлүүлэн "Өргөмжлөл", тухайн жилийн төсвийн боломжид тулгуурлан дараах мөнгөн шагнал олгоно.

Тэргүүн байр 1 Аймгийн тэргүүний багийн "Өргөмжлөл", 500.0-1000.0 мянган төгрөг

Хоёрдугаар байр 1 Аймгийн тэргүүний багийн "Өргөмжлөл" 400.0-700.0 мянган төгрөг

Гуравдугаар 1 Аймгийн тэргүүний багийн "Өргөмжлөл", 300.0-600.0 мянган төгрөг

Тусгай шагнал 2 Аймгийн тэргүүний багийн "Өргөмжлөл", 250.0-500.0 мянган төгрөг

5.2. Оны тэргүүний багийн Засаг даргыг гадаад оронд жуучлах эрхийн бичгээр шагнана. Дээрх шагналын 10 хувийг багийн ИНХ-ын дарга, 15.0 хувийг Засаг дарга, 10.0 хувийг хүний эмчид, 10.0 хувийг багийн зохион байгууллагчид тус тус урамшуулал болгон олгоно. Багийн төвд үйл ажиллагаа явуулдаг сургууль, хүн эмнэлэг, цэцэрлэг зэрэг төрийн үйлчилгээний байгууллагуудын менежерүүдэд мөнгөн шагналын 30.0 хүртэл хувийг урамшуулал боягон олгоно. Үлдэх хувийг багийн албан ажлын хэрэгцаэнд зарцуулна.

5.3. Өмнө нь аймгийн тэргүүний багаар шалгарч тухайн жилд аймгийн "Жишиг баг"-ийн хөгжлийн хөрөнгө оруулалт авч байгаа багийг аймгийн тэргүүний багаар шалгаруулахгүй:

5.4. Шагналын зарцуулалтын тайлангаа багийн ИНХ-даа танилцуулна.

Сумдаас ирсэн багуудын ХШҮ-ний үзүүлэлтийг үндэслэн аймгийн ЗДТГ-ын ТЗУ-ын хэлтсийн ХШҮ-ний тасгийн гаргасан аймгийн бүх багуудыг цуваагаар байр эзлүүлсэн жагсаалт, аймгийн тэргүүний багуудын үйл ажиллагааг орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийтэд сурталчилна.

АЙМГИЙН ЗДТГазар